МОНГОЛЫН ГОВЬ

АЗИЙНИЙ ӨВД БҮРТГЭГДЭХ БОЛОМЖТОЙ ГАЗАР НУТАГ

Онон Зүүсын Таха Групп, Асуух зүйл байвал бидэнтэй холбогдоно уу:

Онон Зүүсын Таха групп Нийгэмлэг. Монгол дахь төлөөлөгчийн газар

3-р давхар, Сүхбаатарын гудамж - 14, VI хороо, Чингэлтэй дүүрэг

Улаанбаатар-15141, Монгол улс

+976 77112031, 99889762 Имэйл: ilg.ulaanbaatar@gmail.com

Энхжүү тесниг Европын Холбооны Байгаль орчны яаманд Зөвлөх үйлчилгээний хэлтэрхээс (ААР), Тео ба Зүүн Европ, Кавказ, Тео Азийн орнуудад Европын Холбооны хөдөлгөөн хөрөнгө оруулах оюуны өмчийн газар хамгаалах агентраг (БНО) болон Германы Байгаль орчин агентраг (ҮБА) хамтын ажиллагаа байна.

Deutsche Stiftung Weltethe нь тесниг хамтрэн санхүүжүүлж байна болно.

Энхжүү нийтлэлийн агуулгыг зохиогчид хариуцна.

Deutsche Stiftung Weltethe

Succow Stiftung

Umwelt Bundesamt

Federal Agency for Nature Conservation

Federal Ministry for the Environment, Nature Conservation and Nuclear Safety

Federal Ministry of Agriculture, Food and Consumer Protection

МОНГОЛЫН ШИНЖЛЭХ ҮХААНЫ ЯАМ

Ministry of Environment and Tourism

ОЛ ТЕХНИЙН ГАЗАР

Ministry of Food, Agriculture and Light Industry

Тэдгээр нь яагаад чухал болох, ямар ашиг тустай байдаг вэ?

Дэлхийн байгалийн өв газрууд нь хүн төрөлхтний сайн сайхан аж төрөл, уур амьсгалын тогтвортой байдалд хувь нэмрээ оруулан, олон төрлийн өвөрмөц амьтдын амьдрах орчныг бүрдүүлдэг төдийгүй экологийн ховор үйл явц, гайхалтай ландшафтуудыг хадгалан хамгаалж байдаг.

Дэлхийн байгалийн өв газар нутгийн гуравны хоёр нь усны чухал эх үүсвэр бөгөөд тал орчим хувь нь үер, хөрсний гулгалт зэрэг байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг байна. Дэлхийн байгалийн өв газруудын 90 гаруй хувь нь ажлын байр бий болгож, аялал жуулчлалаас орлого олох боломж олгодог.

Дэлхийн байгалийн өв газруудыг нь олон улсын хэмжээнд ихэвчлэн таниг дсан тул тэдгээрийг хамгаалах ажлын ололт амжилт нь нийтэд хүрч сурталчлагдаж байдаг. Дэлхийн өвийн конвенцоор дамжуулан хамгийн хэрэгцээтэй газарт үйл ажиллагаагаа төвлөрүүлэх, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэсэн удирдлагын шийдлүүдийг гаргахад нөлөөлөх боломжтой.

Дэлхийн өвийн конвенц гэж юу вэ?

Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенц нь 1972 оны 11-р сарын 16-нд ЮНЕСКО-ийн гишүүн орнуудын хамтран баталсан олон улсын гэрээ юм. Өнөөгийн байдлаар уг конвецид **дэлхийн 190 гаруй орон нэгдэн ороод байна.** Дэлхийн өвийн конвенцийн зорилго нь дэлхий нийтийн **хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий соёлын болон байгалийн өвийг** хадгалан хамгаалж, хойч үедээ өвлүүлэн үлдээх явдал юм.

Дэлхийн байгалийн өв гэж юуг хэлдэг вэ?

Дэлхийн байгалийн өв газрууд нь биологийн олон янз байдал, экосистем, геологи эсвэл байгалийн гайхалтай үзэгдлээрээ ялгарсан дэлхийн хэмжээнд байгалийн хувьд хамгийн онцгой газрууд юм. Конвенцид зааснаар дараахь зүйлүүдийг "байгалийн өв" гэж үзнэ. Үүнд:

- Гоо зүйн болон шинжлэх ухааны үүднээс авч үзвэл дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий физик, биологийн тогтоц, эсвэл ийм тогтоцын бүлгээс бүрдсэн байгалийн өвөрмөц шинж төрх; шинжлэх ухаан болон хадгалан хамгаалах үүднээс авч үзвэл Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий амьтан, ургамлын нэн ховордсон төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчныг бүрдүүлдэг геологи, физиологийн тогтоц, нарийвчлан тодорхойлсон газар нутаг; эсвэл шинжлэх ухаан болон хадгалан хамгаалах үүднээс авч үзвэл Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий нарийвчлан тодорхойлсон байгалийн бүс нутаг болон байгалийн үзэсгэлэнт газар нутгууд орно.

Монголын говь – Дэлхийн өвд бүртгэгдэх боломжтой газар нутаг

Мазаалай, хавтгай, тахь, хулан зэрэг Монгол орны хувьд бэлгэдлийн болон оюун санааны өндөр ач холбогдол бүхий өвөрмөц, нэн ховор шүхэр төрөл зүйлүүдийн өлгий нутаг юм. Монголын говь бол цар хүрээ болон олон талт байдал, онгон дагшин чанараараа дэлхийд гайхагддаг. Монгол орны Говийн Их Дархан цаазат газар, Говийн Бага Дархан цаазат газрууд нь ховор амьтан, ургамлын нэн чухал популяци, мөн цөлийн олон төрөлт онгон зэрлэг, үзэсгэлэнт ландшафт, онцлог шинж чанарыг агуулдаг. 2014 онд Монгол Улсын Засгийн газраас ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн конвенцийн урьдчилсан жагсаалтад "Монголын говийн элсэн цөл нутаг"-ийг оруулахаар өргөн мэдүүлсэн бөгөөд Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас нэр дэвшүүлэхэд шаардагдах баримт бичгийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх хүсэлтийг ЮНЕСКО-д тавьсан билээ.

Монголын Говийн Их болон Говийн Бага Дархан цаазат газруудыг Дэлхийн өвд нэр дэвшүүлснээр Дэлхийн өвийн конвенцийн газар нутгуудад буй цөөн томоохон зай завсарыг дүүргэхийн зэрэгцээ эдгээр гайхамшигтай ландшафт, экосистемийн менежмент, хамгаалалтыг сайжруулахад хөрөнгө оруулах, цаашид улам бүр сайжруулахад үндэсний шийдвэр гаргах байгуллагуудыг урамшуулах, байгаль хамгаалах горим журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх боломжтой.

Монгол Улсын Засгийн газар нь Говийн бүсийн Дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнийг хүлээн зөвшөөрч, Говийн Их Дархан цаазат газрын "А" болон "Б" хэсэг, Говийн Бага Дархан цаазат газрын "Б" хэсгийн газар нутгийг ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхээр нэр дэвшүүлэх урьдчилсан жагсаалтад оруулах хүсэлтийг гаргасан.

Михайл Зукковын сан нь байгаль хамгаалах чиглэлээр Герман-Монгол Улсын урт хугацааны хамтын ажиллагаанд тулгуурлан Монгол Улсын хүсэлтийг дэмжин, Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, тэдгээрийн Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаад болон ЮНЕСКО-ийн Монголын үндэсний комисстой нягт хамтран ажиллаж байна. Энэ ажлын зорилго нь нэр дэвшүүлэх материалыг (viii - Дэлхийн түүхийн гол үеүд, түүний дотор амьдралын түүхэн дурсгалыг тэмдэглэсэн, газар зүйн нөлөөнд хэлбэржин хөгжсөн, эсвэл геоморфик эсвэл физиологийн чухал шинж чанаруудыг харуулсан гайхалтай газрууд), (ix - Хуурай газар болон далай тэнгисийн экосистемийн дагуу бүрэлдэн тогтсон хосгүй үнэт тогтоц бүхий эх газар, далайн эрэг, ургамал амьтны аймаг) болон (x - Байгалийн болон биологийн өвөрмөц тогтоцыг агуулсан дэлхий нийтийн хосгүй гайхамшигт үнэ цэнэ бүхий устаж үгүй болох аюулд өртөж байгаа шинжлэх ухааны хамгаалалтад орсон газрууд) гэсэн Дэлхийн өвийн конвенцын шалгууруудын дагуу боловсруулах явдал юм.

Нэр дэвшүүлэх үйл явц нь олон нийтийн оролцоотой байх ёстой бөгөөд үүнийг тухайн газар нутагт тулгарч буй аюул, дарамтыг арилгахад сонирхогч олон талуудын анхаарлыг хандуулах, говийн бүсийн өвөрмөц үнэт зүйлсийг хадгалан хамгаалахад анхаарал хандуулах механизм болгон ашиглах ёстой.

"Монголын говь"-ийн санал болгож буй бүрэлдэхүүн хэсгүүд

Санал болгож буй урьдчилсан жагсаалтын бүрэлдэхүүн хэсгүүд:

1	Говийн Их Дархан цаазат газар А хэсэг	4.600.000 га
	Ээж хайрхан уул Байгалийн дурсгалт газар	22.475 га
2	Говийн Их Дархан цаазат газар Б хэсэг	1.800.000 га
	Алагхайрхан Байгалийн нөөц газар	36.700 га
3	Говийн Бага Дархан цаазат газар А хэсэг	1.150.000 га
4	Говийн Бага Дархан цаазат газар Б хэсэг	680.000 га
	Нийт талбай	**8.252.475 га**



Монголын говийг Дэлхийн өвд нэр дэвшүүлэх ажлын хүрээнд:

2023 оны 6 дугаар сард Михайл Зукковын сан, Олон улсын Тахь групп, Монголын шувуу хамгаалах төв болон Норвегийн Хэрэглээний шинжлэх ухааны Их сургуультай хамтран Монголын говийг Дэлхийн өвд нэр дэвшүүлэх төслийг эхлүүлсэн. Энэхүү төслийн үндсэн зорилго нь говь нутгийн байгаль, соёлын өвийг хойч үедээ өвлүүлэн үлдээх, хадгалан хамгаалах зорилгоор түншүүд болон талуудын өргөн оролцоотойгоор нэр дэвшүүлэх ажлын бэлтгэлийг хангахад оршино.

Төслийн хүрээнд дээрх зорилтот бүсэд газар дээр нь очиж, зөвлөлгөөн, оролцогч талуудтай хамтарсан уулзалтууд зохион байгуулах, мөн нутаг дэвсгэрт тулгарч буй бэрхшээл, аюул дарамтыг арилгах, хамтын шийдэл хайх зорилготой.

Оролцогч талуудын хамтын ажиллагаа, дэмжлэгүйгээр бид амжилтанд хүрэх боломжгүй. Байгаль орчныг хамгаалах, хүн ардыг нь дэмжихэд Та бидэнтэй нэгдэнэ гэдэгт итгэлтэй байна!

Асуух зүйл байвал бидэнтэй холбогдоно уу!